

## БИЗНЕСИЙН УДИРДЛАГА ДОКТОРЫН ХӨТӨЛБӨР

ЭЛСЭГЧИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН: Магистр  
СУРАЛЦАХ ЖИЛ: 3 жил

**ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО.** Нягтлан бодох бүртгэл, санхүү банкны үйл ажиллагааг зохион байгуулж удирдах, эдийн засаг, бизнес, санхүүгийн орчин үеийн хандлагуудад үндэслэн судалгаа шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад зөвлөгөө өгөх чанартай судлаач бэлтгэнэ.

Бизнесийн удирдлагын онол арга зүйн мэдлэгийг шинжлэх ухааны гүнзгий түвшинд эзэмшүүлж, бизнес, менежментийн асуудлыг онол, арга зүйд тулгуурлан судалгаа шинжилгээний ажил хийх ур чадварыг бүрэн эзэмшүүлж, нийгэм элийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах эрдэмтдийг бэлтгэнэ.

**ЗОРИЛТ 01.** Зах зээлийн эрэлт хэрэгцээ, улс орны хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн, бүтээлч сэтгэлгээтэй, мэдээлэл харилцаа холбооны шинэ дэвшилд үнэлгээ, дүн шинжилгээ хийхэд зайлшгүй шаардлагатай мэдлэгийг эзэмшсэн, зах зээлд хүртээмжтэй өргөн хүрээний мэдлэг чадвартай судлаач эрдэмтэн бэлтгэнэ.

**ЗОРИЛТ 02.** Дэвшилтэт сургалт, судалгаа шинжилгээ, инновацад суурилсан үйлчилгээгээр дамжуулан, судлаачдад эзэмшсэн боловсролоо шинэчлэн сайжруулах, шинэ бүтээгдэхүүн, шинэ зах зээл бий болгох чадвар олгох ахисан түвшний боловсрол эзэмшүүлнэ.

**ЗОРИЛТ 03.** Системтэй цогц мэдлэгийг олгох замаар нягтлан бодох бүртгэл, санхүү банк, менежментийн чиглэлээр бие даан судалгаа хийх, өөрийгөө хөгжүүлэх, эрдэм шинжилгээний стандартыг бүрэн эзэмшсэн, судалгааны ажлын шинэ санаа, түүний үр дүн нь үндэсний болон бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц судлаачийг бэлтгэнэ.

**ЗОРИЛТ 04.** Бизнесийн удирдлагын үйл явц, хүчин зүйлс хоорондын хамаарлыг өндөр түвшинд загварчилж, эдийн засаг, бизнесийн аливаа асуудалд дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнг үйлдвэрлэл болон үйлчилгээнд ашиглах түүний хэрэгжүүлэлтийг зохион байгуулах, удирдах болон асуудлыг зөв оновчтой шийдвэрлэх чадвартай мэргэжилтэн судлаачдыг бэлтгэнэ.

### ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого болон боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг хандлагатай нийцүүлэн эдийн засаг, бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээн хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн, иргэний өндөр боловсрол, соёл, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх, эрдмийн эрх чөлөөг хангахад оршино.

Дээрх зорилтод чиглэсэн

- Мэргэжлийн хичээлүүд
- Мэргэшүүлэх хичээлүүд
- Эрдэм шинжилгээний ажил
- Диссертаци гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

### МЭРГЭЖЛИЙН ХИЧЭЭЛҮҮД

Өнөөдрөөс бизнесийн орчинд, бизнесийн мэргэжлийг эзэмшиж буй хүн заавал, сурч мэдсэн байх ёстой мэдлэг, сурсан мэдлэгээ хэрхэн хэрэглэх практик дадлага болон мэргэжлийн мэдлэгийг олж авна. Үүнд:

- Шинжлэх ухааны судалгааны арга зүй
- Менежментийн эдийн засаг
- Судалгааны арга зүй
- Эдийн засгийн онол, бодлого

### МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛҮҮД

Мэргэжлийнхээ дагуу зайлшгүй шаардлагатай онол, арга зүйн мэдлэг, практик дадал, чадварыг эзэмших бөгөөд Менежмент, Санхүү банк, Нягтлан бодох бүртгэлийн чиглэлийн аль нэгийг сонгон гүнзгийрүүлэн судална. Үүнд:

- Байгууллага дахь манлайлал
- Корпорацын стратегийн менежмент
- Бүс нутаг, логистикийн менежмент
- Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт
- Санхүүгийн менежмент
- Санхүүгийн хөрөнгө оруулалт
- Санхүүгийн эконометрикс
- Портфель менежмент
- Гүйцэтгэлийн удирдлагын стратеги
- Ахисан түвшний удирдлагын бүртгэл
- Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний арга зүй
- НББ-ийн мэргэжлийн судалгаа
- Ахисан түвшний маркетингийн менежмент II
- Хэрэглэгчийн худалдан авах зан төлөв
- Маркетингийн ахисан түвшний судалгааны арга зүй
- Үйлчилгээний маркетинг
- Санхүүгийн зан төлөв
- Санхүүгийн зах зээл ба деривитив
- Татварын бодлого төлөвлөлт
- Байгууллага хоорондын маркетингийн харилцааны удирдлага
- Бизнес инноваци
- Энтрепренершип

Докторын хөтөлбөрт суралцагч нь гүнзгийрүүлэн судлах чиглэлүүдийн аль нэгийг сонгож, тэрхүү багц бүрийн хичээлүүдийг судалсан байх ба тухайн чиглэлдээ нийцсэн сэдвээр диссертаци бичиж хамгаална.